

ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР АВАХ ЭРХ



Даатгуулагч нь нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 65 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.

1

Даатгуулагч **ЭРЭГТЭЙ 60, ЭМЭГТЭЙ 55 НАС** хүрээд доор дурдсан шимтгэл төлсөн хугацааны болзол хангасан бол өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авна.

Он	Шимтгэл төлж, ажилласан хугацаа
2018	20 жил 3сар
2019	20 жил 6 сар
2020	20 жил 9 сар
2021	21 жил
2022	21 жил 3 сар
2023	21 жил 6 сар
2024	21 жил 9 сар
2025	22 жил
2026	22 жил 3 сар
2027	22 жил 6 сар

Он	Шимтгэл төлж, ажилласан хугацаа
2028	22 жил 9 сар
2029	23 жил
2030	23 жил 3 сар
2031	23 жил 6 сар
2032	23 жил 9 сар
2033	24 жил
2034	24 жил 3 сар
2035	24 жил 6 сар
2036	24 жил 9 сар
2037	25 жил

2

Даатгуулагч нийт 20 жил, эсхүл 25 жилийн 15 жил дараахь мэргэжлээр ажиллаж, шимтгэл төлсөн бол **НАС ХАРГАЛЗАХГҮЙГЭЭР** өндөр насны тэтгэвэр тогтоолгон авна.



20 жил эсхүл
25 жилийн
15 жил

- Гоцлол дуучин
- Бүжигчин
- Агаарын болон хэрэглэлийн гимнастик
- Акробат
- Тэнцвэр
- Уран нугаралт
- Хүнд жингийн үзүүлбэрийн жүжигчин
- Зэрлэг араатан, ан амьтан сургаж тоглуулагч
- Хөөмийчин, найрал хөгжмийн үлээвэр хөгжимчин

3

Нийт 20 жил шимтгэл төлж, ажиллан дараахь нөхцөл, болзолыг хангасан даатгуулагч **ӨРӨӨ ХҮСВЭЛ** өндөр насны тэтгэвэр тогтоолгон авна.

ЭМЭГТЭЙ



7 жил 6 сар хөдөлмөрийн **хортой, халуун** нөхцөлд ажиллан шимтгэл төлсөн **45** нас хүрсэн



10-аас доошгүй жил хөдөлмөрийн **хүнд** нөхцөлд ажиллан шимтгэл төлсөн **50** нас хүрсэн



12 жил 6 сар **малчнаар** ажиллан шимтгэл төлсөн



4 ба түүнээс дээш хүүхэдтэй **50** настай **эх**

ЭРЭГТЭЙ



10 жил **газрын дор, хөдөлмөрийн хортой, халуун** нөхцөлд ажиллан шимтгэл төлсөн **50** нас хүрсэн



12 жил 6 сар хөдөлмөрийн **хүнд** нөхцөлд ажиллан шимтгэл төлсөн **55** нас хүрсэн



15 жил **малчнаар** ажиллан шимтгэл төлсөн

Шимтгэл төлж, ажилласан хугацаанд дараахь хугацааг оруулна:

1. тэтгэврийн даатгалын шимтгэлийг ажил олгогчоос болон даатгуулагч өөрөө төлсөн нийт хугацаа
2. байгууллагын захиалгаар ажлаас чөлөөлөгдөж суралцсан хугацаа
3. цэргийн жинхэнэ албыг байлдагч, түрүүчээр хаасан хугацаа
4. хүүхдээ гурван нас хүртэл асрах чөлөөтэй байсан хугацаа
5. хууль бусаар ажлаас зайлуулагдан мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн хугацаа
6. хууль бусаар ажлаас халагдсан хугацаа
7. иргэний хамгаалалтын болон бусад дайчилгааны хугацаа
8. хөдөлмөрийн чадвар түр алдсан, жирэмсний болон амаржсаны амралттай байсан хугацаа
9. хуульд заасан бусад хугацаа